



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/49

Улаанбаатар хот

Гадаад тэтгэлэгт сургалтад хамруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.37, 5.41, 5.42, 5.43 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, дэд бүтэц, тээврийн яам (MOLIT)-тай хамтран Бүгд Найрамдах Солонгос Улсын “Инчеон” Олон улсын нисэх буудалд зохион байгуулагдах “Нисэх буудлын төлөвлөлт ба нисэх буудлын нүүлгэн шилжүүлэлтийн бэлэн байдал” сэдэвт тэтгэлэгт сургалтад Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын үйлчилгээний газрын Нисэх буудлуудын бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн газрын үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ц.Уянга болон аэродромын үйлдвэрлэл, үйлчилгээ, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Н.Сувдаа нарыг 2022 оны 5 дугаар сарын 08-ний өдрөөс 13-ны өдрүүдэд хамруулсугай.

2. Гадаад сургалтад хамрагдсан тухай тайлан гаргаж ажлын 3 хоногийн дотор удирдлагад тайлагнахыг Н.Сувдаа, Ц.Уянга нарт, ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг нисэх буудлуудын үйлчилгээний газар (С.Нацагдорж)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газар (Г.Батбаяр), Захиргаа удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН